



34

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 08 сарын 24 өдөр


Дугаар 61

Мандалговь

Г Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай Г

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 2.4, 11 дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ Нь:

1. Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2012 онд ашиглалтанд орсон 65-92 ДУА улсын дугаартай 20,990,000 /хорин сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийн анхны өртөгтэй, 20,115,416.82 /Хорин сая нэг зуун арван таван мянга дөрвөн зуун арван зургаан төгрөг наян хоёр/ мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй УАЗ-390942-018 маркын Фермер автомашиныг акталж, хаягдал төмрийн үнээр худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгө актлах ажлыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасах, актальснаас гарах материалыг худалдан борлуулж орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын дарга /Б.Хорлоо/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Уганбаяарт үүрэг болгосугай.



0100142